## Газрын нэгдмэл сангийн цахим систем

Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд заасны дагуу Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд 5 жилд нэг удаа газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэлгэрэнгүй ангиллыг газар ашиглалтын зориулалт тус бүрээр тоолж, тооллого явуулж, Газрын нэгдмэл сангийн цахим системийг байгуулан, түүнд орж буй өөрчлөлтөд тухай бүр хяналт тавин ажиллаж байна.




Монгол Улсын хэмжээнд Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан салбар хоорондын уялдааг хангасан Газрын нэгдмэл сангийн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх нөхцөл бүрдсэн.

Мөн газрын нэгдмэл сангийн тайлан, мэдээг хугацаа хязгаарлалтгүй гаргах, тайлагнах, улс, орон нутгийн бүтээн байгуулалт, хөгжлийн бодлого тодорхойлоход шаардлагатай мэдээллийг бүрдүүлээд байна.

